

					ерөнхийлөн захирагчаар батлуулан ажилласан. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд тус ны 5 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 71 мэдээллийг - Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх; - Мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх - Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх; - Хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх зарчмын дагуу shilen.gov.mn цахим сайтад мэдээллээд байна.	
3.1.6	Архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлнэ.	Хэрэгжилт, хувь	100	50	Байгууллагын хэмжээнд нийт 539 албан бичиг шилжиж ирсэн байна. Үүнээс: Захиргааны хэлтэст-262, Бодлогын хэрэгжилтийн хэлтэст-108, Агаарын чанарын , хэмжилт зохион байгуулалтын хэлтэст-97, Хяналт шалгалтын хэлтэст-66 албан бичиг тус тус ирээд байна. Хугацаандаа шийдвэрлэсэн-431, хугацаа хэтэрч хаасан-7, судлагдаж байгаа-8 албан бичиг байна. Цаашид Архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, MNS 5140-1:2021, 5140-2:2021, 5140-3:2021 стандартын дагуу баримт бичгийн бүрдэл, хэвлэмэл хуудас, тэдгээрт тавих шаардлагыг өдөр тутмын баримт бичгийн бүрдэлтэд хэрэгжүүлж ажиллаж байна. Мөн байгууллагын архивын баримтын хадгалалт хамгаалалт сайжруулах чиглэлээр архивын өрөөнд шаардлагатай тоног төхөөрөмжийг асуудлыг шийдвэрлэж, холбогдох санхүүжилтийг шийдвэрлээд байна.	100

3.1.7	Байгууллагын бараа материал, эд хөрөнгийн тооллогыг хагас, бүтэн жилээр тоолно.	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	2	1	Газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 17-ний өдрийн А/116 дугаар тушаал, 2025 оны 06 дугаар сарын 05-ний өдрийн А/65 дугаартай тушаалаар байгууллагын бараа материал, эд хөрөнгийн тооллогыг хагас, бүтэн жилээр тоолох ажлын хэсгийг 6 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилж, тооллогын ажлыг хийж гүйцэтгэж байна. Энэ оны эд хөрөнгийн тооллого 2025.06.09-06.16 хүртэл хугацаанд тоолж, тооллогын дүн мэдээг Газрын дэргэдэх зөвлөлийн хуралд 2025.06.20 дотор танилцуулахаар бэлтгэж байна. Энэ онд байгууллагад шинээр оффиссын 44 ширээ, сандал, 3 ширхэг иж бүрэн компьютерийг холбогдох байгууллагаас балансаас балансад шилжүүлж авсан болно. Мөн шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгааг, гарган эхний ээлжинд 5 суурин компьютер, 3 өнгөт принтер, 1 скайнер, 1 хард дискийг tender.gov.mn цахим системээс худалдан авалт хийхээр төлөвлөж байна.	100
3.1.8	Байгууллагын дотоод хяналт шалгалт зохион байгуулах удирдамж, төлөвлөгөө боловсруулан батлуулах, хэрэгжилтийг хангаж ажиллах, хяналт тавина.	Хэрэгжилт, хувь	1	2	Байгууллагын дотоод хяналт, шинжилгээ үнэлгээ хийх 2025 оны төлөвлөгөөний дагуу тухай бүрт удирдамж боловсруулан, төлөвлөгөөт хяналт шалгалт 2 удаа хийж газрын даргад танилцуулж ажил сайжруулах зөвлөмж боловсруулан хүргүүлсэн болно.	100
3.1.9	Байгууллагын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана.	Хэрэгжилт, хувь	100	50	Байгууллагын 2025 оны сургалтын төлөвлөгөөг 4 заалт, 5 ажил арга хэмжээг зохион байгуулахаар боловсруулж, 2025 оны 03 дүгээр сарын 18-ний өдөр батлуулсан. - Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хүний нөөц хөгжлийн хэлтсээс зохион байгуулдаг төлөвлөгөөт сургалтад хагас жил байдлаар нийт давхардсан тоогоор 85 албан хаагчдыг сургалтад хамруулж чадавхжуулж ажилласан байна.	100

3.1.7	Байгууллагын бараа материал, эд хөрөнгийн тооллогыг хагас, бүтэн жилээр тоолно.	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	2	1	Газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 17-ний өдрийн А/116 дугаар тушаал, 2025 оны 06 дугаар сарын 05-ний өдрийн А/65 дугаартай тушаалаар байгууллагын бараа материал, эд хөрөнгийн тооллогыг хагас, бүтэн жилээр тоолох ажлын хэсгийг 6 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилж, тооллогын ажлыг хийж гүйцэтгэж байна. Энэ оны эд хөрөнгийн тооллого 2025.06.09-06.16 хүртэл хугацаанд тоолж, тооллогын дүн мэдээг Газрын дэргэдэх зөвлөлийн хуралд 2025.06.20 дотор танилцуулахаар бэлтгэж байна. Энэ онд байгууллагад шинээр оффиссын 44 ширээ, сандал, 3 ширхэг иж бүрэн компьютерийг холбогдох байгууллагаас балансаас балансад шилжүүлж авсан болно. Мөн шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгааг, гарган эхний ээлжинд 5 суурин компьютер, 3 өнгөт принтер, 1 скайнер, 1 хард дискийг tender.gov.mn цахим системээс худалдан авалт хийхээр төлөвлөж байна.	100
3.1.8	Байгууллагын дотоод хяналт шалгалт зохион байгуулах удирдамж, төлөвлөгөө боловсруулан батлуулах, хэрэгжилтийг хангаж ажиллах, хяналт тавина.	Хэрэгжилт, хувь	1	2	Байгууллагын дотоод хяналт, шинжилгээ үнэлгээ хийх 2025 оны төлөвлөгөөний дагуу тухай бүрт удирдамж боловсруулан, төлөвлөгөөт хяналт шалгалт 2 удаа хийж газрын даргад танилцуулж ажил сайжруулах зөвлөмж боловсруулан хүргүүлсэн болно.	100
3.1.9	Байгууллагын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана.	Хэрэгжилт, хувь	100	50	Байгууллагын 2025 оны сургалтын төлөвлөгөөг 4 заалт, 5 ажил арга хэмжээг зохион байгуулахаар боловсруулж, 2025 оны 03 дүгээр сарын 18-ний өдөр батлуулсан. - Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хүний нөөц хөгжлийн хэлтсээс зохион байгуулдаг төлөвлөгөөт сургалтад хагас жил байдлаар нийт давхардсан тоогоор 85 албан хаагчдыг сургалтад хамруулж чадавхжуулж ажилласан байна.	100

					- Удирдлагын академиас зохион байгуулж буй хүний нөөцийг чадвахжуулах, мэргэшүүлэх багц сургалт болох "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх " нь, "Төрийн байгууллагын стратеги төлөвлөлт, "Дизайн сэтгэлгээ", "Байгууллагын зэрэг соёлыг бүрдүүлэх" 4 сэдэвт сургалтад нийт 8 албан хаагч хамрагдаж сертификат гардан авсан болно. - Төрийн албаны зөвлөлийн 30 жилийн ойн хүрээнд Нийслэлийн бүсийн зөвлөгөөнийг 2025.05.28-29-ний "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэглээ" сэдэвт хэлэлцүүлэгт 1, "Төрийн албаны хууль тогтоомжийн хэрэглээ" сэдэвт хэлэлцүүлэгт 2, "Төрийн албан хаагч эмэгтэйчүүдийн карьер хөгжлийг дэмжих, төрийн албан дахь удирдах түвшний жендэр" хэлэлцүүлэгт 1, нийт 4 албан хаагчид оролцсон бна - Албан хаагчдын ур чадвар, харилцаа хандлага, өөрийгөө хөгжүүлэх арга, хувь хүний ёс зүйг дээшлүүлэх зорилгоор "Байгууллагын үнэ цэнэтэй ажилтан, зан төлөвт суурилсан багийн ажиллагаа, байгууллагын соёл" сэдэвт сургалтад нийт 23 албан хаагчдыг хамруулж зохион байгуулж ажилласан - Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх А3 сертификат олгох сургалтад 2025 оны 02 дугаар сарын 07-08-ний өдрийн хооронд 5, 2025 оны 03 дугаар сарын 15-16-ны өдөр 8 нийт 13 албан хаагчдыг хамруулсан. - Нийслэлийн Архивын газартай хамтран 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдөр "Төрийн архивын стандарт, албан хэрэг хөтлөлт" сэдэвт сургалтад нийт 25 албан хаагчдыг хамруулсан.	
--	--	--	--	--	--	--

					- Авлигатай тэмцэх газартай хамтран "Авлигын ашиг сонирголоос урьдчилан сэргийлэх, хууль эрхзүйн мэдлэг мэдээлэл олгох" сэдэвт сургалт байгууллагын нийт 25 албан хаагчдыг хамруулсан.	
3.1.10	Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр болон төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангаж ажиллана.	Хэрэгжилт, хувь	100	50	Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолыг үндэслэн газрын даргын 2025 оны А/02 дугаар /Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг өөрчлөн батлах тухай/ тушаалаар албан хаагчдын цалин хөлсийг 6% нэмэгдүүлсэн. Мөн төрийн үйлчилгээний 11 албан тушаалын цалинг 9-15 хувь хүртэл нэмэгдүүлэх саналыг Газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр хэлэлцүүлж газрын даргын 2025 оны А/37 дугаар тушаалаар 9% нэмэгдүүлсэн. Ингэснээр 2025 оны хагас жилийн байдлаар байгууллагын ТҮ-ний албан тушаалтнуудын цалин хөлс 15% нэмэгдсэн байна. Байгууллагын албан хаагчдыг чадавхжуулах зорилгоор "Хувь хүний динамик хөгжил НЗТББ"-тай хамтран 13 багц цагийн сургалтад алба хаагчдыг хамруулан 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар 4 цагийн сургалтад давхардсан тоогоор 41 албан хаагчийг хамрууллаа. Мөн 2025 оны 03 дугаар сарын 29-ны өдөр хамт олны эв нэгдлийг бэхжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор байгууллагаас нөхөрсөг спорт арга хэмжээг 4 төрлөөр холимог баг тамирчдын дунд зохион байгуулж нийт 33 албан хаагчдыг бүрэн хамруулж, амжилт гаргасан албан хаагчдыг урамшуулсан болно.	100

					Хөдөлмөрийн дотоод журмын 10.7 дахь хэсэгт заасны дагуу Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан нийт ажилтан, алба хаагчдын 0-16 насны нийт 57 хүүхдэд гарын бэлэг гардуулж, 2025 оны эхний хагас жилийн байдлаар Төрийн албаны тухай хуульд заасан төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах заалтын хүрээнд нийт 12,090,000 /Арван хоёр сая ерэн мянга/ төгрөгийг холбогдох хууль, журамд нийцүүлэн газрын даргын тушаалаар гаргаж албан хаагчдын нийгмийн баталгааг хангаж ажилласан байна.	
3.1.11	Байгууллагын батлагдсан төсөв, төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх гэрээг байгуулах ажлыг зохион байгуулна.	Хэрэгжилт, хувь	100	50	2024 оны 12 дугаар сарын 25-ний өдрийн Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 24/33 дугаар тогтоолоор 2025 онд нийт 58,443,946,000 төгрөгийн төсөв батлагдсан. Байгууллагын батлагдсан төсвийн хүрээнд Төсвийн гүйцэтгэлийн сар, улирлын мэдээг сар бүр гаргаж Санхүү,Төрийн сангийн газарт хүргүүлсэн ажиллаж байна. 2025 оны эхний 5 сарын байдлаар Орон нутгийн төсвөөс 31,163,590,800 төгрөг, Үндсэн үйл ажиллагааны орлогоос 8,335,000 төгрөг нийт 31,171,925,800 төгрөгийн санхүүжилт батлагдсанаас Орон нутгийн төсвөөс 15,079,228,702 төгрөг, Үндсэн үйл ажиллагааны орлогоос 20,574,000 төгрөг нийт 15,099,802,702 төгрөгийн санхүүжилтийг хүлээн авч 15,145,849,849.59 төгрөгийн зардлын гүйлгээг гаргаж ажилласан байна. Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар орчны бохирдлын асуудал хариуцсан орлогчийн өгсөн үүрэг даалгаврын дагуу 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдрөөс 03 дугаар сарын 26-ний өдрийг дуустал 5 өрхөд Heat pump	100

				цахилгаан халаагуурыг туршилтаар суурилуулан хэмжилт мэдээллийг гаргаж ажилласан. Мөн Динамик тауэр ХХК Польш улсын Авента компанийн үйлдвэрлэсэн эрчим хүчний хэмнэлттэй агаар сэлгэх тоног төхөөрөмжийг ХУД 20 дугаар хорооны Орхон Хасу ерөнхий боловсролын сургуульд суурилуулсан ангид төхөөрөмж ажиллах үеийн болон ажиллахгүй үеийн харьцуулсан байдлаар дотоод орчны агаар дахь нийтлэг бохирдуулагч бодисын агууламжийг тодорхойлж, нийт 1 сургууль, 14 өрхөд туршилтаар суурилуулан хэмжилт мэдээллийг гаргаж, ажилласан байна. Гэр хорооллын айл өрхийг шинэ дэвшилтэд технологид шилжүүлэх ажлын хүрээнд Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас манай газарт 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 03/119 дугаартай албан бичгээр НХААГ/20240102684 дугаартай "Стандартад нийцсэн ахуйн зуух" худалдан авах тендерт "Экоресурс" ХХК-н нийлүүлэгчээр шалгарсан тухай зөвлөмж, холбогдох тендерийн материалыг ирүүлсэн бөгөөд тендерийн материалыг хянан үзэж тендерийн баримт бичигт тусгагдсан ижил төстэй нийлүүлсэн барааны шаардлагад "Экоресурс" ХХК-иас ирүүлсэн УТ2401300903 дугаартай гэрээний гүйцэтгэл хангалтгүй байсан тул гэрээ байгуулахаас татгалзаж, мэдэгдлийг хүргүүлсэн болно. "Экоресурс" ХХК-иас манай газарт холбогдуулан Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасан. 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр Нийслэлдэх захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хариу тайлбарыг 01/207 дугаар, итгэмжлэл олгох тухай 01/208 дугаартай албан	
--	--	--	--	---	--

					бичгээр тус тус хүргүүлж, 2025 оны 06 дугаар сарын 16 -ны өдрийн 15 цагт хэргийг эцэслэн хянан шийдвэрлэхээр шүүх хурлын тов зарлагдаад байна. 2025 оны эхний хагас жилийн байдлаар байгууллагын хэмжээнд нийт 77 гэрээ байгуулж, нийт 15,759,109,135 төгрөгийн санхүүжилтийг зарцуулаад байна.	
3.1.12	Монгол хэлний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т заасны дагуу төрийн албан хэргийг кирилл болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулах ажлыг байгууллагын хэмжээнд зохион байгуулах, хэрэгжилтийг хангаж ажиллана.	Хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан эсэх	-	Хуулийн хэрэгжилтийн хангаж ажилласан байна.	Монгол хэлний тухай хуулийн 7 дугаар зүйл, 7.2-т заасны дагуу кирилл үсгээс монгол бичигрүү хөрвүүлэх кимо лицензийг байгууллагын нийт 5 компьютерт суулгаж, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100
3.1.13	Хөдөлмөрийн аюулгүй байдлын төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллана.	Хэрэгжилт, хувь	100	50	Хөдөлмөрийн аюулгүй байдлын 2025 оны төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг ханган 3,4-р улиралд албан хаагчдын ажлын байранд тавигдах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг хангах, ажилтан, хөдөлмөр эрхлэгч иргэнийг эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэхтэй холбоотой арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.	70
3.1.14	Агаарын бохирдлыг бууруулах мастер төлөвлөгөөг боловсруулж, бэлтгэл ажил хангуулна.	Төлөвлөгөө, тоо	1	1	Агаарын бохирдлыг бууруулах мастер төлөвлөгөөг боловсруулах ажил хойшлогдсон болно.	ҮБ
3.2. Авилгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, авилга, ашиг сонирхлын эсрэг суртачилгааны ажил зохион байгуулна.						
3.2.1	Байгууллагын дэргэдэх ёс зүйн дэд хороо нь Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд үйл ажиллагааны	Зохион байгуулсан арга хэмжээ, тоо	1	1	Байгууллагын Ёс зүйн дэд хорооны 2025 оны төлөвлөгөөг 3 бүлэг 7 заалттайгаар 04 дүгээр сарын 01-ний өдөр батлуулсан болно. Уг төлөвлөлтийн хүрээнд "Хувь хүний динамик хөгжил" ТББ-тай хамтран 13 багц цагийн	100

	төлөвлөгөө боловсруулж хэрэгжилтийг хангана.				сургалтыг "Багаар ажиллах чадамж", "Байгууллагын соёл, ёс зүй" сэдвээр 4 цагийн сургалтад давхардсан тоогоор нийт 41 ажилтан албан хаагчдыг хамруулсан. Мөн 2025 оны 06 дугаар сарын 13-ний өдөр "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэглээ" сэдвээр сургалт зохион байгуулахаар Хүний нөөцийн хөгжлийн төвийн сургалтын хуваарьт тусгуулан бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Цаашид төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, шинээр томилогдсон албан хаагч нарт байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, болон холбогдох хууль тогтоомж таниулах ажлыг зохион байгуулахаар төлөвлөж байна.	
3.2.2	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2024-2030 он)-г хэрэгжүүлж, Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ.	Хэрэгжилт, хувь	100	50	2025 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 6 заалт, 18 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдөр Газрын даргаар батлуулан, төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран "Авлигын ашиг сонирголоос урьдчилан сэргийлэх, хууль эрх зүйн мэдлэг мэдээлэл олгох, хууль бус давуу байдал гэж юуг ойлгох " зэрэг сэдвийн хүрээнд нийт 30 албан хаагчдыг хамруулан сургалт зохион байгуулсан болно. АТГ-аас бэлтгэсэн зурагт хуудсыг байгууллагын албан ёсны Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар фэйсбүүкийн цахим хуудас https://aprd.ub.gov.mn вэбсайтад, мөн сурталчилгааны самбарт АТГ-аас бэлтгэн гаргасан " Авлигын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлийн талаар гомдол гаргах, Иргэн та Авлигын эсрэг юу хийж чадах вэ?" брошурыг нийт албан хаагчдад танилцуулж, байгууллагын	100

					мэдээллийн самбарт байршуулсан. Нийт давхардсан тоогоор 400 гаруй иргэнд хүрсэн байна. "Авилгын эсрэг нэгдье" стикерийг хэлтсүүдийн өрөө, гарах орох хэсэгт байршуулан урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол хэрэгжүүлж байна. Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалтын хүрээнд төсвийн орлого, түүний зарцуулалт, хуваарилалтыг тухай бүр байршуулж олон нийтэд мэдээлж ажиллаж байна. Мөн Shilendans.gov.mn сайтад сар бүр болон тухай бүр оруулах мэдээлэлд Байгууллагын бүтэц, орон тоо, хөрөнгө, зардал гаргах тушаал шийдвэрүүдийг тухай бүр цахим санд оруулж байна. Цаашид байгууллагын үйл ажиллагаатай холбогдуулан эрхлэн гаргадаг ном, гарын авлага, хэвлэмэл материал зэрэгт авлигын хор хөнөөлийг иргэдэд ойлгуулах, шүгэл үлээхийг сурталчлан таниулсан, түүнд уриалсан мэдээлэл болон авлигын мэдээлэх 110 дугаарыг оруулан сурталчлах чиглэлээр ажиллахаар төлөвлөж байна.	
3.2.3	Байгууллагын жендерийн эрх тэгш байдлын тухай үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллана.	Хэрэгжилт, хувь	100	50	Тус газар нь Жендерийн эрх тэгш байдлыг хангах 2025 оны төлөвлөгөөг 6 ажил арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөсөн болно. Байгууллагад нийт 31 албан хаагч ажиллаж, хүйсийн харьцааг авч үзвэл эрэгтэй-15, эмэгтэй-16 байна. Насаар нь авч үзвэл 25-34 насны 19, 35-44 насны 13, 45-54 насны-1 албан хаагчид байна. Жендерийн эрх тэгш байдлыг хангах ажлын хүрээнд 5 заалт 7 ажил бүхий төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. "Жендерийн тэгш оролцоог хангах тухай" сэдвийн хүрээнд танилцуулгад байгууллагын нийт 7 албан хаагчдыг хамруулсан. Цаашид төрийн албан дахь жендерийн эрх тэгш байдлыг	100

					хангах чиглэлээр тодорхой ажил арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөж байна.	
3 зорилгын 5 зорилтын 43 арга хэмжээний дундаж хувь -94,8						

Төлөвлөгөөг хянасан:

Төсвийн Ерөнхийлөн захирагч

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ

Х.НЯМБААТАР

Тэмдэг

2025 оны ... сарын ... өдөр

Төлөвлөгөө тайлагнасан:

Төсвийн Шууд захирагч

НИЙСЛЭЛИЙН АГААР, ОРЧНЫ БОХИРДОЛТОЙ
ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.МӨНХБААТАР

Тэмдэг

2025 оны ... сарын ... өдөр